



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2017-03-24 № 7/2172

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Улсын төрөлжсөн олимпиадын Мэдээлэл зүйн хичээлийн 2-ын давааг Ховд аймгийн харьяат, Монгол Улсын их сургуулийн Хэрэглээний шинжлэх ухааны, инженерчлэлийн сургуулийн Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхимийн багш, доктор, профессор Ж.Пүрэвийн нэрэмжит болгон, Ховд аймагт зохион байгуулахыг Мэдээлэл зүйн олимпиадын дэд хорооны даргатай ярилцаж, харилцан зөвшөөрлөө.

Мэдээлэл зүйн олимпиадын 2-ын даваа 2017 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр болох бөгөөд энэ үеэр МУИС-ын мэдээлэл, компьютерийн ухааны тэнхимийн эрдэмтэн багш нар Ховд аймгийн мэдээлэл зүйн багш нарт зориулсан сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулж, оюуны хөрөнгө оруулалт хийх гэж байгаад талархал илэрхийлье.

Аймгийн хэмжээнд олимпиадын 2-ын даваа нь арван гурван хичээлийн төрлөөр багш, суралцагчид олноор оролцож, ачаалал ихтэй ажиллдаг тул Та бүхэн Ховд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай цаг хугацааг урьдчилан төлөвлөж, хамтарч ажиллана уу.

Хувийг: Ховд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



М.МӨНХБААТАР

03 01241